



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/247

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зохицуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нөхөн сэргээлт, хяналт шалгалт-1" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	П.Мөнхбаяр	Аймгийн Цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Энхбат	Аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч
Гишүүд:	Г.Маналжав	Мэргэжлийн хяналтын газрын геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч
	Б.Мөнхжаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхай, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн явах маршрут, шатахууны тооцоог хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах 186.000 нэг зуун наян зургаан мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүү тэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн

231011544

дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

05 Аймгийн Засаг даргын 2021 оны  
дугаар сарын 19 өдрийн А/247  
дугаар захирамжийн хавсралт



“ХЯНАЛТ-ШАЛГАЛТ-1” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД АЖИЛЛАХ  
МАРШРУТ. ШАТАХУУНЫ ТООЦОО

№	Маршрут	Сум хоорондын зай /км/	Шатахуун /бензин/ тооцоо
1	Чингис хот–Баян-Адарга	140	120 литр Бензин (л) 1550 төгрөг
2	Баян-Адарга-Норовлин	80	
3	Норовлин-Баян-Овоо	120	
4	Баян-Овоо-Батноров	50	
5	Батноров-Бэрх	40	
6	Бэрх–Чингис хот	70	
	Нийт	800 км	186,000 (нэг зуун наян зургаан мянган) төгрөг